



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 05 сарын 03 өдөр

Дугаар A/33

Улаанбаатар хот

“Сити тур” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1.4.6, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 47 дугаар тогтоол, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 1-50, тус газрын дүрмийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдын хэрэгцээнд нийцсэн хотын аяллын шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох, гадаад, дотоодын жуулчдын сонирхлыг татах арга хэмжээний тоог нэмэгдүүлэх, нийслэл Улаанбаатар хотын түүх соёл, аялал жуулчлалын үзмэр, хотын өнөөгийн хөгжилтэй танилцуулах зорилготой “Сити тур” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхийг Мэдээлэл сурталчилгааны хэлтэс /М.Болортуяа/-т даалгасугай.

2. Төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг хавсралтад дурдсаны дагуу холбогдох зардлаас гаргахыг нягтлан бодогч /Б.Батцож/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА *D. Balsan* Д.БАТСҮХ



1150500193

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2019 оны 05
сарын 03 өдрийн А/33 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

5284325 СБТ-8936 1118263502

“СИТИ ТУР” ТӨСЛИЙГ ҮРГЭЛЖЛҮҮЛЭН ХЭРЭГЖҮҮЛЭХ
ТӨСВИЙН ЗАДАРГАА

2019.05.03

Улаанбаатар хот

№	Зарцуулалт	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Хөтөч, жолоочийн малгай, хэвлэл	4	8 000	32 000
2	Хөтөч, жолоочийн футболк, хэвлэл	10	30 000	300 000
3	Аяллын тасалбар	2 000	396	792 000
4	Танилцуулга нугалбар, эх бэлтгэл	10 000	660	6 600 000
5	Дардас /тамга/	2	20 000	40 000
6	Маркетингийн зардал	1	1 000 000	1 000 000
Тээврийн хэрэгсэлтэй холбоотой зардал				
7	Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг оношлогоо	2	33 300	66 600
8	Тээврийн хэрэгслийн албан татвар	2	132 000	264 000
9	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	2	225 000	450 000
10	Шатахуун	2*1 000л	2 350	4 700 000
11	Техник хэрэгслийн бусад зардал	2	577 700	1 155 400
Цалин хөлс				
12	Менежерийн цалин	1*3	1 200 000	3 600 000
13	Хөтчийн цалин	2*3	1 000 000	6 000 000
14	Жолоочийн цалин	2*3	1 000 000	6 000 000
НИЙТ				31 000 000